

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2018 ОНЫ ЭХНИЙ 9 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

I. УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2017 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **1,595.2** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **49.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **603.7** тэрбум төгрөг,
- Цайр **63.3** тэрбум төгрөг,
- Зэс **800.8** тэрбум төгрөг,
- Төмөр **12.3** тэрбум төгрөг,
- Жонш **12.4** тэрбум төгрөг,
- Бусад **53.7** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **847.9** тэрбум төгрөг буюу **113.4 (2.1 дахин)** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **4.1 (9.0%)** тэрбум төгрөг;
- Нүүрс **461.5 (4.2%)** тэрбум төгрөг;
- Цайр **29.0 (84.5%)** тэрбум төгрөг;
- Зэс **336.3 (72.4%)** тэрбум төгрөг;
- Жонш **7.1 (2.3 дахин)** тэрбум төгрөг;
- Бусад **13.0 (31.9%)** тэрбум төгрөг;

Харин төмөр **3.0 (19.8%)** тэрбум төгрөгөөр буурсан байна.

2018 оны эхний 9 сарын байдлаар улсын төсөвт **1,562.5** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **51.7** тэрбум төгрөг,
- Нүүрс **652.1** тэрбум төгрөг,
- Цайр **62.2** тэрбум төгрөг,
- Зэс **716.5** тэрбум төгрөг,
- Төмөр **13.3** тэрбум төгрөг,
- Жонш **12.4** тэрбум төгрөг,
- Бусад **54.3** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **487.1 (45.3%)** тэрбум төгрөгөөр өссөн. Үүнээс:

- Алт **18.0** тэрбум төгрөг буюу **53.4** хувь,
- Нүүрс **263.8** тэрбум төгрөг буюу **67.9** хувь,
- Цайр **17.6** тэрбум төгрөг буюу **39.4** хувь,
- Зэс **159.8** тэрбум төгрөг буюу **28.7** хувь,
- Төмөр **5.8** тэрбум төгрөг буюу **76.3** хувь,
- Жонш **7.2** тэрбум төгрөг буюу **140.7** хувь,
- Бусад **14.9** тэрбум төгрөг буюу **37.9** хувь,

УТ-т төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

№	Үзүүлэлт	2017		2018		Өөрчлөлт			
		IX	I-IX	IX	I-IX	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9
	Нийт дүн	91.64	1,075.37	122.08	1,562.47	30.4	33.2%	487.1	45.3%
1	Алт	3.76	33.68	7.03	51.68	3.3	86.9%	18.0	53.4%
2	Нүүрс	34.06	388.31	58.85	652.08	24.8	72.8%	263.8	67.9%
3	Цайр	2.73	44.61	2.00	62.21	-0.7	-26.8%	17.6	39.4%
4	Зэс	48.18	556.70	47.74	716.50	-0.4	-0.9%	159.8	28.7%
5	Төмөр	0.40	7.55	0.62	13.32	0.2	56.3%	5.8	76.3%
6	Жонш	0.90	5.14	1.54	12.37	0.6	72.2%	7.2	140.7%
7	Бусад	1.61	39.39	4.30	54.33	2.7	166.5%	14.9	37.9%

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

2018 оны эхний 9 сарын байдлаар **33.5** сая тн нүүрс, **979.4** мян.тн зэсийн баяжмал, **14.5** тн алт, **4.0** мян.тн молибдений баяжмал, **2.5** сая тн төмрийн хүдрийн баяжмал, **57.1** мян.тн хайлуур жоншны баяжмал, **62.6** мян.тн цайрын баяжмал, **5.0** сая баррель газрын тос, **10.5** мян.тн катодын зэс үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал **16.0 (1.7%)** мян.тн, хайлуур жоншны баяжмал **19.2 (50.7%)** мян.тн, цайрын баяжмал **2.0 (3.3%)** мян.тн-оор тус тус өссөн байна. Харин нүүрс **2.7 (7.5%)** сая тн, молибдены баяжмал **294.5 (6.8%)** тн, алт **248.0 (1.7%)** кг, төмрийн хүдрийн баяжмал **179.6 (6.7%)** мян.тн, газрын тос **710.4 (12.4%)** мян.бар, катодын зэс **481.8 (4.4%)** тн-оор тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2017		2018		Өөрчлөлт			
			IX	I-IX	IX	I-IX	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	4,443.1	36,176.5	4,377.7	33,469.8	-65.4	-1.5%	-2,706.7	-7.5%
1.2	Газрын тос	мян.бар	632.0	5,720.1	515.4	5,009.7	-116.6	-18.4%	-710.4	-12.4%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	104.9	963.4	119.0	979.4	14.1	13.4%	16.0	1.7%
1.4	Молибдений баяжмал, м/агуулгаараа	тн	433.3	4,337.5	419.9	4,043.0	-13.4	-3.1%	-294.5	-6.8%
1.5	Алт	кг	2,785.7	14,770.9	2,582.2	14,522.9	-203.5	-7.3%	-248.0	-1.7%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдрийн олборлолт	мян.тн	997.5	5,903.5	674.6	4,672.6	-322.9	-32.4%	-1,230.9	-20.9%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	455.5	2,674.8	588.6	2,495.2	133.1	29.2%	-179.6	-6.7%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны олборлолт	мян.тн	16.2	87.5	12.6	90.2	-3.6	-22.2%	2.7	3.1%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	3.6	37.9	12.8	57.1	9.2	255.6%	19.2	50.7%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	8.8	60.6	7.0	62.6	-1.8	-20.5%	2.0	3.3%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	966.7	10,933.8	848.8	10,452.0	-117.9	-12.2%	-481.8	-4.4%
2.2	Металл бэлдэц	тн	1,710.1	15,435.6	2,483.5	20,857.2	773.4	45.2%	5,421.6	35.1%
2.3	Металл цувимал	тн	604.1	12,897.6	2,173.7	22,287.5	1,569.6	259.8%	9,389.9	72.8%

Тайлбар: ¹ – Дахин их

II.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл

тэрбум төгрөг

Салбар	2017		2018		Өөрчлөлт			
	IX	I-IX	IX	I-IX	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,254.6	9,455.2	1,410.5	11,235.4	155.9	12.4%	1,780.3	18.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	952.3	6,925.2	1,039.1	8,098.8	86.8	9.1%	1,173.6	16.9%
Нүүрс олборлолт	232.3	1,845.4	348.5	2,703.9	116.2	50.0%	858.5	46.5%
Газрын тосны олборлолт	75.0	674.4	88.8	801.3	13.8	18.4%	126.9	18.8%
Металлын хүдэр олборлолт	634.7	4,320.1	586.1	4,489.4	-48.6	-7.7%	169.3	3.9%
Бусад ашигт малтмал олборлолт	10.3	85.3	15.8	104.2	5.5	53.0%	18.9	22.2%
Боловсруулах аж үйлдвэр	240.2	1,881.3	299.8	2,390.8	59.7	24.9%	509.5	27.1%

Эх сурвалж: УСХ

2018 оны эхний 9 сарын байдлаар Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл **11.2** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.7 (18.8%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **8.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (16.9%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **858.5 (46.5%)** тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт **169.3 (3.9%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.1%**-ийг эзэлж байна.

II.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн

тэрбум төгрөг

Салбар	2017		2018		Гад-дал	Өөрчлөлт			
	IX	I-IX	IX	I-IX		(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,331.6	11,040.4	1,767.3	13,143.6	9,108.2	435.7	32.7%	2,103.1	19.0%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	983.9	7,701.4	1,255.6	9,090.8	7,595.7	271.7	27.6%	1,389.4	18.0%
Нүүрс олборлолт	247.6	2,293.8	439.8	2,958.5	2,764.5	192.2	77.6%	664.7	29.0%
Газрын тос олборлолт	67.5	663.8	72.9	769.3	769.3	5.5	8.1%	105.5	15.9%
Металлын хүдэр олборлолт	657.2	4,656.5	727.3	5,254.5	3,981.6	70.1	10.7%	598.0	12.8%
Бусад ашигт малтмал олборлолт	11.7	87.4	15.6	108.5	80.3	3.9	33.7%	21.1	24.2%
Боловсруулах аж үйлдвэр	285.7	2,690.1	440.4	3,304.1	1,512.4	154.7	54.1%	614.0	22.8%

Эх сурвалж: УСХ

2018 оны эхний 9 сарын байдлаар Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **13.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **2.1 (19.0%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **9.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.4 (18.0%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **3.0** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **664.7 (29.0%)** тэрбум төгрөг, металлын хүдэр олборлолт **5.3** их наяд төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс **598.0 (12.8%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүнээс гадаад зах зээлд нийт **9.1 (69.3%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэр **7.6 (57.8%)** их наяд төгрөгийн борлуулалтыг тус тус хийсэн байна.

II.4. Гол нэрийн бүтээгдэхүүний үлдэгдэл

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	Өөрчлөлт			
							(6-4)=?, (6/4)=%		(6-5)=?, (6/5)=%	
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Нүүрс	мян.тн	7,624.7	3,614.4	7,947.0	4,408.9	794.5	22.0%	-3,538.1	-44.5%
2	Катодын зэс, 99%	тн	2,212.9	3,021.8	889.7	1,388.7	-1,633.1	-54.0%	499.0	56.1%

Эх сурвалж: УСХ

II.5. Аж үйлдвэрийн салбарт ажиллагчид, дэд салбараар

Бүтээгдэхүүний төрөл	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX	2018 I-IX	Өөрчлөлт			
					(5-3)=?, (5/3)=%		(5-4)=?, (5/4)=%	
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	65,346	65,041	69,667	74,100	9,059	13.9%	4,433	6.4%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	25,384	24,065	25,158	24,506	441	1.8%	-652	-2.6%
<i>Нүүрс олборлолт</i>	8,696	7,484	7,745	8,161	677	9.0%	416	5.4%
<i>Газрын тос олборлолт</i>	1,683	1,676	2,473	1,613	-63	-3.8%	-860	-34.8%
<i>Металлын хүдэр олборлолт</i>	13,300	12,931	13,055	12,885	-46	-0.4%	-170	-1.3%
<i>Бусад ашигт малтмал олборлолт</i>	1,705	1,974	1,885	1,847	-127	-6.4%	-38	-2.0%
Боловсруулах аж үйлдвэр	26,072	25,967	29,593	31,917	5,950	22.9%	2,324	7.9%
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	13,890	15,009	14,916	17,677	2,668	17.8%	2,761	18.5%

Эх сурвалж: ҮСХ

III. ГАДААД ХУДАЛДАА

2018 оны эхний 9 сарын байдлаар Гадаад худалдааны нийт бараа эргэлт **9,633.8** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **1,920.2 (24.9%)** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **931.7** сая ам.доллараар эерэг гарсан байна.

III.1. Экспорт

Экспорт **5,282.8** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **699.9 (15.3%)** сая ам.доллараар өссөн байна.

Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.5%** буюу нийт экспортын **84.6%**-ийг эзлэж байна.

Экспортлосон боловсруулаагүй нефть, төмрийн хүдэр болон цайрын баяжмалыг **100%**, зэсийн баяжмалын **99.2%**, чулуун нүүрсний **99.1%**-ийг БНХАУ-д; жоншны **58.6%**-ийг БНХАУ-д, **41.2%**-ийг ОХУ-д; боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтыг **100%** Их Британид тус тус экспортлосон байна.

III.2. Импорт

Импорт **4,351.0** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс **1,220.3 (39.0%)** сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **976.0** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **238.4** сая ам.доллараар буюу **32.9%**-иар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **83.5%**-ийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. Энэ оны эхний 9 сард **814.7** сая ам.долларын **1,184.9** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортлосон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **133.8** мян.тн-оор, үнийн дүнгээр **224.8** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **80.1%**-ийг автобензин, дизель түлшний импорт, үүний **33.6%**-ийг автобензин, **66.4%**-ийг дизель түлшний импорт эзлэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

Барааны нэр	Хэмжих нэгж	2017 I-IX			2018 I-IX			Өөрчлөлт		
		Тоо хэмжээ	Үнийн дүн	Дундаж үнэ (ам.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн	Дундаж үнэ (ам.дол)	Тоо хэмжээ	Үнийн дүн	Дундаж үнэ (ам.дол)
Чулуун нүүрс	тн/мян.\$	25,532,577.4	1,724,320.2	67.5	27,027,329.9	2,122,309.7	78.5	1,494,752.5	397,989.5	11.0
Зэсийн баяжмал	тн/мян.\$	1,084,451.9	1,155,531.2	1,065.5	1,072,963.2	1,487,609.4	1,386.4	-11,488.7	332,078.1	320.9
Боловсруулаагүй нефть	бар/мян.\$	5,636,314.8	272,315.0	48.3	4,811,726.3	316,096.4	65.7	-824,588.5	43,781.3	17.4
Төмрийн хүдэр	тн/мян.\$	4,360,208.0	231,498.1	53.1	5,314,689.7	240,389.8	45.2	954,481.7	8,891.7	-7.9
Цайрын хүдэр, баяжмал	тн/мян.\$	90,711.7	133,612.0	1,472.9	92,164.3	153,460.5	1,665.1	1,452.6	19,848.5	192.1
Жонш	тн/мян.\$	215,657.7	55,198.0	256.0	344,675.1	115,698.6	335.7	129,017.5	60,500.6	79.7
Молибдены хүдэр, баяжмал	тн/мян.\$	4,924.2	27,534.2	5,591.6	4,428.6	36,019.9	8,133.5	-495.7	8,485.7	2,542.0

Эх сурвалж: ГЕГ

